



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/127

Бат-Өлзий сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийг үндэслэн Хөдөө аж ахуй, газар тариаланд шаардлагатай трактор худалдан авах тендерийг 81,975,000 (наян нэгэн сая есөн зуун далан таван мянга) төгрөгөөр “Мөнх ногоон тал” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Зардалд шаардагдах 81,975,000 (наян нэгэн сая есөн зуун далан таван мянга) төгрөгийг гэрээний дагуу, Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгө данснаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч гэрээний дагуу санхүүжилт өгөхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

